

МОНГОЛЧУУДЫН ЦАЙНЫ СОЁЛ:

Бэлгэдэл, зүйрлэл, нийгмийн явцын оршихуй

Габи Бамана *

Монгол айлд орсон зочин гийчин болгон монголчуудын зочломтгой занг мэдэж авах боломжтой. Тухайн айлын гэр бүлийн гишүүд ч гэсэн зочин гийчинг хүлээн авах ёс журамтай байдаг юм гэдгийг багаасаа мэдэрч, түүнд суралцаж, эзэмшсэн байдаг. Энэхүү зочломтгой сэтгэлгээг бэлгэдэж байгаа зүйлийн нэг нь цай мөн байна. “Цайгүй айл царайгүй” гэж монголчууд ярьдаг зүйргүй үнэн үг байна. Цай нь айл гэрийн халуун сайхан сэтгэлийн илэрхийлэл хэмээн монголчууд өөрсдөө үздэг.

Миний бие хээрийн судалгаагаар монголын өргөн уудам нутгаар аялан явж байхдаа монголчуудын чанадаг олон төрлийн цай амсан ууж, мөн цайтай холбоотой зан үйлийг тэмдэглэж, цайны холбогдолтой эдлэл хэрэгслийн зүйлийг цуглуулж, мөн цаашлаад монгол аман зохиолд байдаг цайны холбогдолтой зүйлийг бичиж тэмдэглэн авч, өөрийн судалгааны гол судлагдахуун болгон авч үзэж байгаа зэргээс үндэслэн монголын цайны соёл судалгааны тусгай салбар болох юм гэдэг саналыг дэвшүүлж бичихийг зорьсон болно. Жич, өдөр тутмын амьдралд цайгаар дамжин монголын нийгмийн амьдралын явц зохицуулагддаг нь бодитой үнэн учраас, цай бэлгэдлийн шинж чанартай гэдэг нь үнэн юм. Өөрөөр хэлбэл, монгол хүний хувьд цай бол зөвхөн цангаа тайлах унд бус, харин тэдний өдөр тутмын амьдралын утга учрыг агуулсан бэлгэдлийн нэгж мөн билээ.

Бид энэ удаагийн өгүүлэлдээ, нийгмийн явцад цай бэлгэдэлийн нэгж болж байдаг хэмээн тодорхойлж байгаа бөгөөд энэ өгүүллийн зорилго гэвэл монголыг судлах явцад далдлагдсан нэг сэдэв болох цайны бэлгэдлийн асуудлыг хөндөх юм. Тодруулбал, цай нь монголын соёлын утгыг агуулсан бэлгэдлийн нэгж буюу нийгмийн харилцааны хэв журамын далдлагдсан илэрхийлэл гэж ойлгож байгаа болно.

Цай нь нийгмийн харилцааны бэлгэдлийн утгыг хэрхэн агуулж байгаа вэ гэдгийг өгүүлэхээс өмнө энэхүү өгүүллийн түлхүүр үг хэллэгийг тайлбарлах шаардлагатай гэж үзэж байна. Дараагаар нь цайтай холбоотой нийгмийн явц жишээгээр тайлбарлаж бичнэ. Дүгнэлт хэсэгт цайны бэлгэдлийн шинжийг тодорхойлох болно.

Жорж Лакофф болон Марк Жонсон (George Lakoff & Mark Johnson) нарын хамтын бүтээл болох “*Metaphors we live by*”¹ (1980) -д дэвшүүлсэн зүйрлэл (metaphor)¹² гэдэг

* МУИС-ийн Нүүдлийн Соёл Иргэншил Судлалын Төв

¹ George Lakoff & Mark Johnson (1980) ‘*Metaphors we live by*’ The University of Chicago Press.

² Metaphor гэдэг ойлголтыг монгол судлаачдын бүтээлүүдэд “зүйрлэл”, “адилтгал” хэмээн нэрлэсэн байдаг ч англи хэлэнд энэхүү ойлголтыг бид нийгмийн шинжлэх ухааны үүднээс энэхүү өгүүлэлд

ойлголтын талаархи шинэлэг санал нь, зүйрлэл зөвхөн уран зохиолын гоо сайхны бичлэгийн маяг биш харин хүмүүний өдөр тутмын амьдрал зүйрлэлээр тооцоологдож, түүгээр жолоодогдож байдаг. Тэд олон оновчтой жишээгээр энэ санаагаа баталсан байдаг.

Лакоф болон Марк Жонсоны харуулсан баримт жишээнүүд нь барууны орны нийгмээс эш авсан байгаа хэдий ч тэдгээрийг монголын өдөр тутмын амьдралтай харьцуулан үзэхэд хүмүүс зүйрлэлээр сэтгэж ярьдаг үнэн юм. Ер нь монголчууд малаа дагаж явдаг учраас хүний зан араншинг муухай, сайхан гэж хэлэхээсээ илүүтэйгээр малынхаа ааш араншингаар төлөөлүүлж хэлдэг. Хэдэн жишээ аваад үзье. Учраа алдсан хэн хүнийг мал мэт амьтан, яаруу яваа хэн нэгнийг хурдан морь шиг л давхиж явна гэх юм уу, хонь шиг ноомой, борооны хонь шиг шуухитнах, ямаа шиг ойворгон, үхэр шиг удаан болхи юм уу үхэр шиг хэвэх, тэмээ шиг өндөр, өндөр намхан хоёр хүнийг тэмээ ямаа хоёр шиг гэх зэргийн зүйрлэл тоочвол олон гарна.

Бидний амьдралын туршлагаас харвал, хүмүүн аливаа зүйлийг ямар нэг юмтай зүйрлэж, бодож ярьдаг. Өөрийн амьдралын туршлагыг ярихдаа гэсэн ч аливаа нэг зүйл мэтээр дүрсэлж ярина. Зүйрлэл нь бидний өдөр тутмын амьдралын учир шалтгааныг агуулж илэрхийлдэг юм. Энэ санаа маш зөв юм. Учир нь зүйрлэл байхгүй, эсвэл аливаа юмыг зүйрлэж мэдэхгүй бол өдөр тутмын амьдралын явц утга учраа илэрхийлэж чадахгүй юм.

Бидний санаж байгаагаар Лакоф болон Жонсон хоёрын санал нь Виктор Турнэрийн саналтай ижил ухагдахууныг хэлж байна. Турнер (1975), *“хүмүүн, гадны ертөнцийг тэмдгээр илэрхийлнэ, харин өөрийгөө бэлгэдлээр илэрхийлнэ”*³ гэсэн. Учир нь чухам юу байна вэ гэвээс хүний туршлага үйл явц зуурхан байдаг болохоор амьдралын аливаа нэгэн учир шалтгааныг бүрэн төгс тодруулж гүйцээгүй, бөгөөд иймэрхүү туршлагыг зөвхөн бэлгэдлээр сэтгэж илэрхийлдэг бололтой юм. Хүн утгатай амьдрахын тулд шинэ шинэ шалтгаан бий болгоно, ингэхдээ энэ шинэ утга шалтгааныг зөвхөн өөр ижил төстэй, адилхан агуулгатай зүйлээр илэрхийлэх болно. Бэлгэдэл нэгжийн агуулга нь бүрэн гүйцэд төгссөн биш болохоор шинээр олсон шалтгаан агуулгаа нэмж баяжуулах бололтой. Энэ шинжээр бэлгэдэл тэмдгээс ялгана.

Бидний өгүүлж буй бэлгэдэл зүйрлэл хоёрын тухай ерөнхий энэ онол нь монголын нийгмийн ойлголттой ч таарна. Манай багш, проф. С.Дуламын (2007) монголын бэлгэдэл зүйн бүтээлд монголын бэлгэдлийн хүрээ салбар буюу монголын бэлгэдлийн 7 гол ангийг үзүүлсэн (тооны, өнгийн, зүг чигийн, дүрсийн, дохио зангааны, зүүд зөн совингийн болон цагийн анги). Харин энэ бүтээлийг уншиж байхад бэлгэдэл ер нь хаана оршиж байгаа билээ? гэдэг нэг асуулт байнга тулгардаг. С.Дулам багш энэ асуултанд тун оновчтой хариулт өгсөн ба *“Монгол бэлгэдэл зүйн тогтолцоо, түүний чанарыг тайлан унших нь”* (2009)⁴ өгүүллийг задлаад үзэхэд бэлгэдлийн тогтолцоо нь соёлын тогтолцоотой адил юм. Харин соёл гэдэг бол нийгмийн амьдралын жолоо юм. Тэгснээрээ бэлгэдлийн учир тайлбарлана гэхэд нийгмийн амьдралын учир шалтгааныг тайлбарлах хэрэг болох юм гэсэн дүгнэлт гарч байгаа юм.

зүйрлэл хэмээх нэр томъёогоор хэрэглэлээ. Мөн эрдэмтэн С.Дулам монголын уран зохиолд метафорыг хэрхэн авч үзэх талаар *“Уран зохиолын үүд”* (Ц.Хасбаатарын хамт 1980) номд байгаа болно.

³ Turner, V. (1975) ‘Symbolic studies’ Annual Reviews, 4, 145 -161.

⁴ Дулам, С. (2009) *“Монгол бэлгэдэл зүйн тогтолцоо, түүний чанарыг тайлан унших нь”*. “Монгол бэлгэдэл судлал” ОУЭШХуралд тавьсан илтгэл. Улаанбаатар.

Мөн тэрбээр (мөн өгүүлэл) “бэлгэдэл бол өдөр тутам болон нийгмийн явцаас үүсдэг”⁵ хэмээн тайлбарласан. Зургаагийн тооны бэлгэдэлийн тухай бичихдээ “нийгмийн хүрэн дэх “зургаа”-ийн бэлгэдлийг дурдвал, хуримд эхлээд хүүгийн тал ерөөл айлтгаж, гурван дуугаа дуулна, дараа нь бэрийн тал ерөөл айлтгаж гурван дуугаа дуулаад найр задгайрна... Тэгэхлээр хуримын эхний зургаан дуу бол хоёр гурвын нийлбэр болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, бэлгэдэл нь нийгмийн үйл явцыг эмхлэн зохион байгуулж байгаа хэрэг мөн буй за”⁶ гэжээ.

Цааш нь үзвэл, С.Дулам багшийн энэ онолын давуу тал нь бэлгэдлийн тогтолцоо, нийгмийн явц хоёр өөр хоорондоо зүйрлэлээр холбоотой, нэг нь нөгөөгөөсөө салахын аргагүй гинжин нэгдэл болох юм гэдэг оновчтой санал байгаа юм. Эндээс үзэхэд, бэлгэдлийн тогтолцоо, зүйрлэл, нийгмийн явц гурвын холбоонд соёл орших болно. Харин түүн дотроо зүйрлэл, хэл яриатай холбоотой болохоор зүйрлэлээр соёлыг илэрхийлнэ гэж бид бодож байна. Мэдээжийн хэрэг соёлыг зөвхөн хэл яриагаар илэрхийлэхгүй гэдгийг бас дурдах хэрэгтэй.

Бидний ойлгосноор зүйрлэлгүйгээр нийгмийн амьдрал өөрөө агуулга муутай болно. Нийгмийн олон анги давхарга өөрийн гэсэн зүйрлэлтэй байдаг (үндсэн зүйрлэл) бөгөөд зүйрлэлийн бүтэц нь л гэхэд аливаа зүйлийн бэлгэдлийн утгаар хүний өдөр тутмын амьдралын учир шалтгааныг өрнүүлнэ басхүү нийгмийн харилцааны хэв журмыг нь зааж өгөх юм. Дээр өгүүлсэн бүхий л шинж чанар нь монголчуудын идээ ундааны дээж-цайгаар илэрдэг. Үүнийг тодорхойлохын тулд судалгааны тэмдэглэлийн тайлбар хийж болоно.

2007 онд миний бие 4 хүний хамт монголын хөдөө нутгаар аялаж явсан бөгөөд бид 5 аянчин дотроос гагц би гадаадын иргэн байсан ба бусад нь монголчууд тэдний дунд нэг эмэгтэй байсан бөгөөд 3 насанд хүрсэн эрчүүд байсан. Бид тавыг орсон айл болгон зочломтгой сайхан зангаар угтаж хүндэлж байлаа. Нэгэн малчин айлд ороход тэр айлын гэрийн эзэгтэй бидэнд цай аягалж өглөө. Миний сонирхлыг татаж байсан зүйл бол монгол хүн зочид гийчид болоод гадны хүнийг маш ихээр хүндэтгэн дээдэлж үздэг ёсорхуу зантай байдаг болохоор энэ удаад цай өгөхөд ч бас нэгэн хүндлэл илэрнэ гэж бодож байлаа.

Тэгээд цайгаа хэнд эхлээд өгөх бол, цай өгөх дэс дараалал архи өгөх дараалалтай адил байх болов уу яах бол гэж сонирхон сууж байлаа. Намайг хамт яваа аянчид болон гэрийнхэн гадаадын хүн гэдэг утгаар нь баруун талын хамгийн дээд талд суулгасан бөгөөд бусад аялагчид ч нас, хүйсийн эрэмбээр суулгасан. Тэгэхэд гэрийн эзэгтэй надад эхлээд цай аягалж өгөөд, дараа нь нас, хүйсийн эрэмбээр нь бус сууж байгаа дарааллаар нь цайгаа өгсөн.

Энэ үйл явцыг тайлбарлах болбол айлд орсон хэнд ч гэсэн цай өгөх ёстой. Энэ нь монголчуудын зочломтгой зангийн хамгийн энгийн, тод хэлбэр хийгээд монгол соёлыг төлөөлөх нэг журам болдог юм. Монгол айлд зочин гийчнээ дайлах олон төрлийн идээ ундааны зүйл байгаа хэдий ч хамгийн эхлээд заавал ч үгүй сүүтэй цайгаар дайлна. Бидний өгүүлж байгаа энэхүү идээ ундааны дээж болж байгаа цай нь цагаан буюу халуун гэсэн хоёр гол шинжийг агуулж байна.

Ер нь монголчуудын тухай ярих болоход бэлгэдлийн тухай дурдахгүй өнгөрч ерөөсөө болдоггүй гайхалтай ард түмэн билээ. Хүний сэтгэл халуун болоод цагаан энэ

⁵ Мөн өгүүлэл

⁶ Дулам, С. (2007, 1999). *Монгол бэлгэдэл зүй-1* (Тооны бэлгэдэл) Улаанбаатар: Битпрэсс

хоёр шинжтэй байдаг бөгөөд ямар нэгэн муу сэтгэл байхгүй гэсэн санааг цагаан өнгөтэй зүйрлэж, харин дулаан уур амьсгалыг халуун цайгаар төлөөлүүлэн бэлгэдэж сүү болсон халуун цайгаар зочноо угтаж авч хүндэтгэдэг байна. Өөрөөр хэлбэл, цай нь айл гэрийн хүмүүсийн сэтгэлийн илэрхийлэл болдог гэсэн дүгнэлт гарч байгаа хийгээд зүйрлэн бичвэл “сүүтэй цай мэт цагаан, халуун цай мэт хүмүүний чин сайхан сэтгэл” баймаар байна.

Цайны энэ хоёр гол шинж нь гүн гүнзгий бэлгэдлийн утгатай. Цагаан өнгө гэдэг харын эсрэг, халуун гэдэг хүйтний эсрэг. Энэ бол сайн (цагаан, халуун)–муу (хар, хүйтэн) хоёрын диалектик харилцаа билээ. Сүүтэй халуун цай бол сайн сайхныг төлөөлж бэлгэдэх учраас хүний цагаан сайхан сэтгэлийг зүйрлэж төлөөлж болно. Мэдээжээр хүмүүний хувьд сайн–муу диалектик нь ёс суртахуунтай холбоотой болохоор хүмүүн сайныг үйлдэх ёстой мууг хийх ёсгүй гэж мэднэ. Бэлгэдлийн ёс суртахууны чанар журмын шинжтэй болно. Энэ журам үйлдсээр байгаад уламжлал болно. Энэ тайлбар бол нутгийн тайлбар биш. Ер нь гэрийн эзэгтэй ямар учир болзлоор зочин гийчгээ цайгаар угтаж авдаг юм бэ гэвэл маш товчхоноор хэлбэл энэ нь монголын уламжлал.

Ийм зүйрлэлээс үүдээд монгол ёсонд хар цай, хүйтэн цай эхлэн зочноо дайлахыг сайнд үздэггүй. Тэгсэн хэдий ч бид өмнө өгүүлснээр бэлгэдлийн дундрашгүй агуулгаараа “хар ч гэсэн хааны рашаан, бор ч гэсэн богдын рашаан” хэмээн эерүүлж зочноо дайлдаг байна. Ихэнхдээ дээрхи үгийг хэлж байгаад зочдодоо өгч байхыг миний бие цөөнгүй удаа үзсэн билээ. Учир нь Виктор Турнэр (1974, 1975)-ийн тайлбарласнаар бэлгэдлийн зүйл нийгмийн явцыг төлөөлөх үүрэгтэй болно. Энэ үүргийг цайгаар тодруулан хэлбэл, хүмүүс бэлгэдлийн эсрэг тэсрэг агуулгын аль алиныг нь ашигладаг бөгөөд бэлгэдлийн нэгж өөрөө олон талтай хийгээд эсрэг тэсрэг учир шалтгаан агуулсан байдаг нь тодорхой (e.g. Turner 1967, 1975). Нийгмийн амьдралын явцад эсрэг тэсрэг үйл явц гардгийн адилаар бэлгэдэлийн нэгж аль алинд нь үйлчлэх үүрэгтэй байдаг. Үнэндээ энэ нь өмнө өгүүлсэн амьдралын зуурхан шинжтэй холбоотой байна. Энэ удаа, бэлгэдлийн гол зүйл цай, шинж нь гэхэд цагаан (сүүтэй) болон халуун, харин зарим тохиолдол цай, хар (хар цай эсвэл бор цай) болон хүйтэн байдаг. Бэлгэдлийн нэгж эсрэг тэсрэг шинж агуулсан учир нь бүх төрлийн нийгмийн байдлыг төлөөлж үйлчилж болно.

Цаашлаад харвал, цайг зочинд аягалах дараалал нь монгол нийгмийн бүтэц болоод тухайн бүтцийг зохицуулж байгаа соёлын зарчимтай адилтгаж үзэхэд болно. Хүнд цай аягалж өгөхдөө ямар дэг журам дагах тухай зан үйлийн тухай өгүүлсэн бусад номоо үзэхэд илүү тодорхой байдаг (Арьяасүрэн, Нямбуу 1992) Харин бидний саналаар энэ журам маань зөвхөн тухайн үед гүйцэтгэж байгаа ажлын дэг жаяг төдийхөн бус соёлын тайлбар ч болох юм. Энэ санааг ойлгохын тул, дээр өгүүлсэн судалгааны тэмдэглэлээ дахин сөхье.

Бид энэхүү цай аягалж өгөх явцыг хэрхэн ойлгож байгаа гэвэл, хүнд цай аягалан өгөх үйл явцыг (үйлчилгээ) ажиглахад монгол соёлын зарчмын ёсоор нийгмийг 2 ертөнц хэмээн сэтгэж хуваадаг: гадаад ертөнц болон дотоод ертөнц. Бид энэ хоёр ертөнцийг манайх (дотоод) болон танайх (гадаад) гэж нэрлэсэн (Бамана 2011). Танайх гэдэг ертөнц нь танихгүй ертөнц учраас тэндээс ирсэн хүн нь таньдаг ч бай, таньдаггүй ч бай гаднаас ирж байгаа учраас гадаад ертөнцийг сэтгэж тэднийг түрүүлээд дайлдаг. Манайх гэдэг ертөнц нь зочдыг угтаж тосч авч байгаа айл гэрийнхэн юм. Гэсэн хэдий ч энэ нь танайх ертөнц, манайх ертөнцөөс дээр, илүү гэсэн санаагаар биш харин ч гадаад

ертөнц бол танихгүй нийгмийн хүрээ учраас ямар нэгэн муу аюул юм уу, муу эрчим ирэх магадлал маш ихтэй байдгаас үүдэн тэрхүү аюул болохоос түрүүлж хамгаалж байгаа хэрэг болох юм.

Айлд орсон зочин гийчид ер нь нас, хүйсийн эрэмбээр голцуу суудаг. Нас, хүйс хоёр нийгмийг ангилдаг зарчим гэдгийг аягатай цай харуулдаг боловч дэс дарааллаар байх алба үгүй. Гэхдээ ер нь монгол нийгэм эцгийн эрхт ёс нь давамгайлдаг гэж судлаачид үздэг (Нямбуу 1992), зарим тохиолдолд өндөр настай эмэгтэй бусдын дээд талд нь суудаг нь тэдний насыг хүндэлж байгаа хэрэг гэж монголчууд ярьдаг. Үнэндээ, нас, хүйс хоёр нийгмийн гишүүдийн өөр хооронд нь ялгах бэлгэдлийн гол зарчим (Foucault) юм. Цай энэ хоёр зарчмыг хоёуланг нь агуулсан бэлгэдлийн зүйл мөн байна.

Бид энэ өгүүлэлдээ цайны соёл гэж монголчуудын тусгайлан авч үзэх ёстой нэгэн соёл байдаг гэсэн санал дэвшүүлээд мөн жишээгээр цайны бэлгэдлийн шинж батлан харуулж байна. Цай зөвхөн нийгмийн явцыг зохицуулж байгаа биш, цаашлаад нийгмийн зөрчил тэмцлийг ч зохицуулна. Бид өөрсдийн орсон ихэнх айлын гэрийн эздэд *“хэрэв танай эхнэр, өглөө цайгаа аягалж өгөхгүй эсвэл аягалсан хирнээ таны гарт бариулж өгөхгүй ширээн дээр тавина. Та юу гэж бодох вэ”* гэсэн маягтай асуултатавирахад тэд бүгд нэг дуугаар *“энэ нь бидний хооронд ямар нэгэн эвгүй уур амьсгал болсон байна гэж үзнэ”* гэсэн нэгэн ижил утга бүхий хариултуудыг өгч байсан. Энэ нөхцөлд маань цайны соёл гэр бүлийн хүрээний соёл мөн гэсэн санааг шууд илэрхийлж байгаа бөгөөд ийм нэгэн адилтгах зүйрлэлийг монголчуудын алдарт *“Гэсэр”*-ийн туужаас басхүү харж болно. Гэсэрийн тууж (1986)-ийн Хятадын Гонма хааны төрийг зассан гутгаар бүлэгт *“... Рогма гуай хэлэв: “Ай! Сэцэн Нанжун минь босон гүйж оч! Хурдан ир! Алтан хөвөөт аргалаар доторло! Мөнгөн хөвөөт аргалаар гадарла! Усан эх мэт буй. Ихээхэн хий. Давс зээ мэт буй. Багаахан хий. Цай эцэг мэт буй. Багаахан хий. Сүү нагац мэт буй. Ихээхэн буй. Тос ноён мэт буй. Багаахан хий. Буцлахад сүүн далай долгиох мэт сана. Самрахад олон бурсан хувраг ном унших мэт сана. Уухад алтан цэгцгийг нүхэнд ороход адил сана. Арван зүгийн эзэн арван хорын үндсийг тасалсан авай богд минь заларч байна. Цай яарч чана”*⁷ гэснээс тодорхой харж үзэж чадна.

Цайгаар монголчуудын өдөр тутмын амьдралыг судлахад боломжтой. Цай бол бэлгэдлийг өөртөө шингээсэн байдаг учир нийгмийн амьдралын учир агуулсан гэдэг нь үнэн юм. Мэдээжийн хэрэг монголын цайны соёл монголын нийгмийн тусгай мөн чанартай болохоор тухайн соёл нь энэ тусгай чанарыг дагаж явна. Монголчууд зөвхөн цангаа тайлах ундаа төдий бус харин соёлын зарчмыг илэрхийлж бас тэд өөрсдийгөө төлөөлж илэрхийлэх гэж цайг хэрэглэдэг.

⁷ (1986) *Гэсэр* Монгол ардын аман зохиолын чуулган VIII цуврал (Сонгомол эхийг боловсруулж удиртгал тайлбар бичсэн Ц.Дамдинсүрэн, редактор Ш.Гаадамба) Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр, 68 тал.

SUMMARY

This paper discusses social metaphors in Mongolian tea culture. It analyses few cases to argue that the use of tea in Mongolia has symbolic meaning which connects it to social process. Tea is a symbolic element able to represent human process because its properties are used to signify meaning individuals bestow on their actions. This paper argues about the concept of a Mongolian tea culture.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

АА (1986) *Гэсэр* Монгол ардын аман зохиолын чуулган VIII цуврал (Сонгомол эхийг боловсруулж удиртгал тайлбар бичсэн Ц.Дамдинсүрэн, редактор Ш.Гаадамба) Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр, 68 тал.

Арьяасүрэн.И, Нямбуу.Х. (1992) *Монгол ёс заншлын их тайлбар толь*. Улаанбаатар.

Дулам, С. (2009) “Монгол бэлгэдэл зүйн тогтолцоо, түүний чанарыг тайлан унших нь”. “Монгол бэлгэдэл судлал” ОУЭШХуралд тавьсан илтгэл. Улаанбаатар.

Дулам, С. (1999, 2007). *Монгол бэлгэдэл зүй-1* (Тооны бэлгэдэл) Улаанбаатар: Битпрэсс

Нямбуу.Х. (1992) *Монголын угсаатны зүй* (Удиртгал) Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр

Англи хэлээр:

Bamana, G. (2008) *On the tea road (a journey into Mongolian life and culture)*, Ulaanbaatar: Bitpress

Bamana, G. (2011) Men on the right, women on the left: Symbolism and metaphor in the Mongol Ger domestic space, (forthcoming)

Foucault (1977) *Power/Knowledge*, Selected interviews & Other writings 1972-1977 [Gordon, C. (ed.); Gordon, C., Marshall, L., Mephram, J. & Soper, K. (trans.)],

George Lakoff & Mark Johnson, (1980) *Metaphors we live by*, The University of Chicago Press.

Turner, V. (1967) *The forest of symbols: aspects of Ndembu rituals*. New York: Cornell University press.

Turner, V. (1974) *Dramas, fields and metaphors: symbolic action in human society*. Ithaca, New York and London: Cornell University Press.

Turner, V. (1975) *Symbolic studies Annual Reviews*, 4, 145 -161.